

ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

**«МОНГОЛ ҮНДЭСТНИЙ ТҮҮХЭН ХҮМҮҮСИЙН
ТУХАЙ ЦОМОРЛИГ» БЭЭЖИН 1981.
(Шүүмж)**

Хятадад сүүлийн хориод жил монголын түүхийн бүхий л гурван үеийн томоохон үйл явдлуудыг гуйвуулан бичсэн олон ном, зохиол гарчээ. Эдгээр зохиолын өвөрмөц онцлог нь Монгол улсыг хятадын нэг хэсэг байсан гэсэн санааг нотлоход чиглэгдсэнд оршино.

Хятадын түүхчдийн шинжлэх ухааны ямар ч үндэслэлгүй баримтлалд монгол, зөвлөлтийн түүхчид марксист-ленинист методологийн үүднээс удаа дараа зүй ёсны няцаалт өгч байсан билээ.

Хятадын түүхчид түүх гуйвуулахдаа ихэнх тохиолдолд маоист баримтлалдаа захируулан монголын түүхэнд ямар нэг талаар нэрд гарсан хүмүүсийн үйл ажиллагааны мөн чанарыг элдвээр мушгин гуйвуулж байна.

1981 онд Бээжинд хэвлэгдэн гарсан «Монгол үндэстний түүхэн хүмүүсийн тухай цоморлиг» гэдэг номд тийм маягийн оролдлого хийжээ. Уг зохиолын оршилд Монгол үндэстэн бол «манай (хятадын) улсын олон үндэстний холбоог бэхжүүлэн хөгжүүлэхэд асар их хувь нэмэр оруулсан» гэх мэтээр бичжээ. Энэ зохиолд орсон бүх өгүүлүүд ийм санаанд захирагджээ.

Уг номд Чингис хааны талаар гурван өгүүлэл орсон байна. Булин, Лю Цзинсуо «Чингис хааны амьдралын эхний хагасыг товч үнэлэхэд» Шу Чжанбан «Чингис хааны өмнө зүгт хийсэн дайны зорилго, ач холбогдлын тухайд», ЧжаоЮнчунь «Чингис хаан монголыг нэгтгэх болсон учир шалтгааны тухайд» зэрэг болно. Дээрх өгүүлүүд утга санааны хувьд Чингис хааны талаар хятадын түүхчдийн урьд өмнө (60 оноос хойш, бичиж байсан зүйлээс онцын ялгаагүй байна.

Өгүүлүүдэд Монголчуудыг хятадын нэг үндэстэн болгон, Чингисээс хятадыг эзлэн түрэмгийлсэн явдлыг хятадын хаан ширээний төлөө тэмцэл байсан мэтээр бичжээ. «Монгол үндэстэн манай (хятад) үндэстний цөөнх юм. Иймээс монгол үндэстний хаан хятадын хаан болох бүрэн эрхтэй юм» (21-р тал) гэж Шу Чжанбан өгүүлэлд бичээд: «Дахин сэргэн мандаж байсан монгол үндэстний төлөөлөгч Чингис хаан Алтан улс руу довтолсон явдал, хятадын тал газрын ард түмний Алтан улсын ялзран доройтсон төрийг түлхэн унагаах гэсэн шаардлага, удаан хугацаагаар хойд өмнө зүгт тархай бутархай амьдарч байсан ард түмний нэгдэх гэсэн эрмэлзэлтэй нийцэж байсан» (21-р тал) гэж түүхийг гуйвуулан бичсэн нь Чингисийн Алтан улс руу дайрсан явдлыг «нэг гэр бүлд» болсон явдал мэт харуулахыг зорьсон хэрэг байв. Гэтэл Чингис хаан Алтан улсыг эзлэн түрэмгийлсэн үе нь хятадын ард түмэн зүрчдын Алтан улсын ялзарсан төрийг эсэргүүцэн тэмцэж байсан үетэй давхцсан ба Алтан улсын төр улмаар доройтсон байсан учир Чингис хааны олз болсон билээ.

Цоморлигт Монголын Юан улсын хаан Хубилайн талаар бичсэн Вэй Фэн, Ван Лу хэмээх хүмүүсийн «Хубилайн хуучныг үгүйсгэн шинийг бий болгох бодлого», Бай Суйцин «Хубилайн энх амгалан байдалд үйлдвэр, цэрэг, хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлогын тухай товч дурдахад» гэсэн хоёр өгүүлэл оржээ. Эдгээр өгүүлэлд Хубилай хаан хятадын хувьд харийн булаан эзлэгч байсныг үгүйсгэн «Юан, гүрнийг хятадын гүрэн байсан буюу түүнийг хятадын нэг үндэстэн болох монголчууд» захирч байсан мэтээр бичжээ. Вэй Фэн, Ван Лу нар «Монгол үндэстэн хятадын тал газар руу орж суурьшихдаа газар тариалангийн талбайг бусниулж нэг улс дахь үндэстнүүдийн хоорондын зөрчлийг хурцатгасан» гэх мэтээр бичсэн нь монголчуудын түрэмгийллийн харгис мөн чанарыг үгүйсгэх, зөвхөн ах дүү үндэстнүүдийн «нэгэн гэр бүлд болсон будлиан маргаан» мэтээр тайлбарлах гэсэн оролдлого юм. Гэтэл Хубилай хаан хятадын хувьд эзлэн түрэмгийлэгч байсан ба хятадын ард түмний тэр үед хийж байсан тэмцэл нь харийн булаан эзлэгчдийн эсрэг шууд чиглэгдэж байсан билээ. Ийм ч учраас Хубилай хаан өөрийн байр суурийг бататгаж хятадын ард түмний эрх чөлөөний тэмцлийг сулруулахын тулд эзлэн авсан хятад оронд зохих ёсны хэв журмыг тогтоон зарим нэгэн шинэчлэлтийг хийхэд хүрсэн билээ. Хубилай хаан хятадын ард түмнийг дарлан мөлжиж монголын феодалуудын эрх ашгийг эхнээсээ аваад дуустал хамгаалж байжээ.

«Алтан хаан ба Фэйчжоучуаны район¹ дахин хагас тариаланжсан хагас мал аж ахуйжсан нь» хэмээх Цзао Юнньань гэдэг хүний өгүүлэлд «Алтан хаан Фэйчжоучуаны районд газар тариалан, мал аж ахуйг хөгжүүлж байсан нь хятад улсын түүхэнд зохих байр суурийг эзлэх юм» гэж хятадын түүхэнд хамааруулан бичжээ. Уг өгүүлэлд, Мин улс, улс төрийн гүнзгий хямралд орж ангийн болон үндэсний дарлал хурцадсанаас болж Монголтой худалдаа хийх явдлыг 40 гаруй жил хойш нь татсан боловч Алтан хааныг Фэйчжоучуаны районыг эзэмшихэд объектив бололцоогоор хангасан мэт бичжээ. (109-р тал) Ингэж Цзао Юнньань гэгч Мин улс Монголтой худалдаа хийхийг татгалзаж, эдийн засгийн дарамт үзүүлж байсныг элдвээр цагаатгахыг оролджээ. Гэтэл Мин улс монголын хувьд шууд эзэрхэг түрэмгий бодлого явуулж байв. Алтан хаан Мин улсын тэрхүү бодлогын эсрэг олон жилийн турш тэмцсэн хүний нэг юм. Тийм ч учраас Алтан хаан Мин улсын заналт дайсан Алтан хааны толгойг авчирсан хүнд их шан өгнө гэж зарлаж байсан байна.²

Мин улс Монголд шууд түрэмгийлэн эдийн засгийн шахалт хавчилт үзүүлж байснаас гадна олон тооны хятад хүмүүсийг Монгол руу хүчээр оруулан Монголыг уусгах бодлогыг явуулж байсныг дээрх зохиогч монголчуудын аж байдал доройтож, амьдрах бололцоогүй болоход хятад хүмүүсийг нүүлгэн очуулж туслуулж байснаар тайлбарлажээ. (111 -р тал)

Ян Цзянсин хэмээх өөр нэг зохиогчийн «Монгол үндэстний улс төрийн зүтгэлтэн Алтан хаан» гэдэг өгүүлэлд Мин улс Монгол хоёрын харилцаа байлдааны улмаас хурцадмал байдалд байсныг зөвхөн Монголын хаад Юан улс мөхсөний дараа өөрийн эрх мэдлээ эргүүлж авах гэж оролдож байсан мэт өрөөсгөл тайлбарлажээ. Гэтэл Мин улсын эзлэн түрэмгийлэх бодлогын бүрэлдэхүүн хэсэг бол эдийн засгийн хавчлага байсан гэж бид дээр тэмдэглэсэн билээ. Иймд Мин улсын улс төрийн бодлогыг эдийн засгийн бодлогоос саланга авч үзэж болохгүй

¹ Өнөөгийн БНХАУ-ын Өвөр Монголын автономит районы нийслэл Хөх хотын ойролцоо байдаг район.

²История Монгольской Народной Республики. М., 1983. 185-р тал

юм. Алтан хаан Мин улсын эдийн засгийн хавчилтыг эсэргүүцэж, олон жилийн турш хятадыг довтлон байлдаж байжээ. Мин улсын төрийн зүтгэлтэн Ван Чугу монголчуудын ийнхүү урт удаан хугацаагаар довтлон байгаа гол шалтгаан бол эдийн засгийн үндэстэй. Учир нь нүүдэлчид суурьшсан ардуудын тариа, будаа, бөс даавуу, гэр орны аар саар хэрэглэгдэхүүнээр үргэлж гачигдаж байдаг байна. Тэдний бэрхшээл гачигдал арилаагүй цагт Хятад орныг уулгалан дээрэмддэг нь огт зогсохгүй. Иймийн тул Алтан хааны хүссэн ёсоор алба барих худалдаа хийхийг зөвшөөрөх хэрэгтэй гэж хаандаа дахин давтан сануулж байжээ.¹

Нөгөө талаас Хятадын эсрэг Алтан хааны хийж байсан дайн бол мөн чанараараа XIII зууны эзлэн түрэмгийлэх дайнаас нилээд өөр юм. Уг дайн нь Мин улсын эдийн засгийн хавчлага хяналтын эсрэг түүний илэрхий түрэмгийллийн эсрэг тусгаар тогтнолоо хамгаалсан дайн байсан юм. Иймээс Алтан хааныг зөвхөн Хятадтай худалдаа хийх гэж тэмцэж байсан гэж үзвэл хангалтгүйгээр үл барам Мин улсын эзлэн түрэмгийлэх бодлогын эсрэг монголчуудын явуулж байсан тэмцлийн мөн чанарыг гуйвуулахад хүрэх билээ.

Алтан хаан Монголд шарын шашин дэлгэрүүлсэн явдлыг «Хятад улсын баруун болон хойд зүгт оршиж буй төвд монгол үндэстнүүдийн холбоог зузаатгаж улсын нэгдлийг хангахад зохих үүргийг гүйцэтгэсэн юм». (135-р тал) гэжээ. Монголыг хятадын хэсэг байсан гэж үзэж болохгүйн адил Төвдийг ямагт хятадын хэсэг байсан мэтээр хэзээ ч үзэж болохгүй билээ. Төвд Юан гүрний хараат улс болохоос өмнө тусгаар тогтносон улс байсан бөгөөд Юан улс мөхсөний дараа хятад улсын нэгэн адил тусгаар тогтнолоо сэргээсэн юм.

Монголд шарын шашин дэлгэрсэн тухайд гэвэл монголын феодалууд тухайлбал, Алтан хаан шарын шашны тусламжтайгаар дотоод улс төрийн байдлыг бэхжүүлэх, Мин улсын түрэмгийллээс тусгаар тогтнолоо хамгаалах давхар зорилго тавьж байжээ.

Ма Манмэй гэдэг хүний бичсэн «Баатар хунтайж ба Хаант Орос» хэмээх өгүүлэлд Зүүнгарын хаант улсыг хятадын хэсэг байсан мэт бичсэн байна. «Зүүнгарын улс бол хятадын баруун хойт талын хил дээр оршиж түүний хаан Баатар хунтайж Хаант Орос улсын түрэмгийллийн эсрэг тэмцэж байсан хятадын цөөнх үндэстний баатар» мэт болгон бичжээ. Гэтэл үнэн хэрэг дээрээ Баатар хунтайж манжийн түрэмгийллийг зайлуулахын тулд Хаант Оростой эв найрамдалтай байхыг чухалчилж байсан юм.

Ма Манмэй гэгч цааш нь бичихдээ Зүүнгарын хаант улс нэг хэсэг хугацаанд Чин улсын захиргаанаас гарсан нь тухайн үеийн нөхцөлтэй холбоотой юм (172-р тал) гээд тэр тухайн үеийн нөхцөлийг тайлбарлахдаа: 1. Мин улсын төр мөхөж, Чин улсын төр тогтож байсан, өөрөөр хэлбэл хоёр төрийн зааг дээр эмх замбараагүй үе байсан. 2. Хошууд аймгийн Төрбайх Чин улсад дагаар орсон учир Чин улс Баатар хунтайжийн засгийг хүлээн зөвшөөрөөгүй юм гэжээ. Зохиогчийн үзэж байгаагаар Чин улс «өөрийн харьяанд буцаж орж улсын нэгдлийг хангасан хошууд аймгийг сайшааж байсан нь зүйтэй боловч ойрдуудыг нэгтгэсэн Баатар хунтайжийг хүлээн зөвшөөрөөгүй явдал Чин улсын улс төрийн алдаа байжээ. (173-р тал). Баатар хунтайж, түүний үе залгамжлагч Сэнгэ хятадад захирагдаж байснаа хүлээн зөвшөөрч байсан гэж дээрх зохиогч бичжээ. Энд тэмдэглэхэд Зүүнгарын хаант улс хэзээ ч хятадын харьяа байгаагүй билээ. Нөгөө талаас хошуудын Төр-

¹ Мин улсын Даданы шасгир 327-р тал. «БНМАУ-ын түүх» 1-р боть. УБ., 1966.

байхын талаар гэвэл 1635—1638 онд Хөх нуур руу нүүж, бие даасан хошуудын улс байгуулсан буюу улс төрийн хувьд бэхжихийн тулд Чин улстай холбоо тогтоосон байсан боловч түүнийг Чин улсын хараат улс байсан гэж үзэж болохгүй. Манжийн дарлалд орох нь бол хожуу хойно болсон явдал юм. Тэр үед Баатар хунтайжаас Манжийн хувьд баримталж байсан байр суурийн хувьд гэвэл Зүүнгарын хаант улс Чин улстай ойртохоос болгоомжилж байсан ба хятадтай бараа таваар солилцох гэсэн сонирхол хүртэл Манжийн эсрэг тэдний байр суурийг өөрчилж чадаагүй билээ. Баатар хунтайжийн бодлогыг түүний үе залгамжлагчид өвлөн авч тууштай хэрэгжүүлсэн бөгөөд түүний хүү Галдан манжийн эзлэн түрэмгийллийн эсрэг зэвсэг барин тэмцжээ.

Гэтэл Чжан Чжихуан хэмээх хүн «Галдан ба Төвдийн шашин төрийн толгойлогчдын холбооны тухай товч өгүүлэхэд» хэмээх өгүүлэлдээ манжийн түрэмгийллийн эсрэг Галдан бошигтын явуулж байсан тэмцлийн мөн чанарыг гуйвуулж Зүүнгарын хаант улс хятадын нэг хэсэг байсан гэж нотлохыг оролдож, мөн түүнийг Төвдийн Далай ламтай эвсэн хятад улсын нэгдлийг эвдэн Чин улсаас тусгаарлах бодлого явуулсан мэт бичжээ. Ингэж бичихдээ Чжан Чжихуан Галдан бошигтыг төвдийн тавдугаар Далай ламын дуулгавартай зарц байсан мэт бичиж Зүүнгарын хаант улсыг манжийн эсрэг нөлөө бүхий бие даасан хүч байсныг үгүйсгэсэн байна. Тухайлбал тэр бичсэн нь: «Чин улсын нэгдлийг хамгаалж байсан Гуши хааны залгамжлагчдын эсрэг тэмцэн, Төвдөд тогтож байсан тэдний засгийг сулруулан төвдийн шашин төрийн толгойлогчдын зарц болж байсан» гэжээ. (206-р тал).

Галданы үйл ажиллагааны эхний хэсэг нь Зүүнгарын хаант улсын доторхи хагарал бутарлыг давах, Хөх нуурын хошууд аймагтай холбоо тогтоох, феодалын хамжлагат ёсыг бэхжүүлэх, шарын шашныг дэлгэрүүлэхэд чиглэгдэж байжээ. Галдан шарын шашны тусламжтайгаар өөрийн байр суурийг бататгах, мөн шарын шашны тугийн дор Монголыг нэгтгэхийг эрмэлзэж байв. Нөгөө талаас Төвдийн эрх баригчид Галданд түшиглэн Төвдийн бие даасан байдлыг сэргээх гэж оролдож байжээ. Чин улсын түрэмгий бодлого идэвхжсэнээр энэ хоёрын холбоо шууд манжийн эсрэг хандлагатай болсон байна.

Галдан манж-хятадын түрэмгийллийн аюулыг зайлуулахын тулд Монголыг нэгтгэхийг эрмэлзэж байв¹. Тэр үед Халх, Манж Чун улсын хараат болон хувирсан байлаа. Галдан Халхын нутагт орж ирсэн нь Халхыг гүйцэд эрхэндээ оруулах гэж байсан Манжийн бодлогод аятайхан шалтаг болжээ.

Чжан Чжихуан мөн «Галдан бошигтын Халх руу дайрсан явдал бол Чин улсын нэгдлийг эсэргүүцсэн хэрэг» гэж бичжээ. Тухайлбал «Галдан Хаант Орос улсын ятгалга, төвдийн эрх баригчдын тусламжтайгаар улс орны нэгдлийг сарниулж, умард зүгийг Хятадаас тусгаарлах шудрага бус дайн хийхийг оролдож байсан» (208-р тал). Мөн «Хаант Оросоос Хятадын умард хязгаарыг эзэмших гэсэн түрэмгий бодлогыг Түшээт хан эсэргүүцэн дайтаж байсан яг энэ үед Галдан бошигт Халх руу дайрсан явдал Хаант Оросын сонирхолд нийцэж байсан юм» гэжээ. (208— 209-р тал)

Хэрэг дээрээ Манж Чин улс, Түшээт хан Чахуундоржийн Оростой хийсэн хил хязгаарын талаархи маргааныг өөрийн эзлэн түрэмгийлэх бодлогын үүднээс чадамгай ашиглаж Чахуундоржийг байн байн турхирч Монгол Оросын айл хөршийн найрамдалт харилцааг муутгахыг

1 Б. П. Гуревич. Международные отношения в Центральной Азии в XVII первой половине XIX в, М., 1979, 47-р тал.

оролдож байв. Нөгөө талаас Түшээт хан, Галдан Бошигттой байлдаж түүнд дийлэгдэх үед ч гэсэн манжид даган орох эсэхийг бүрмөсөн шийдэж чадахгүй тээнэгэлзэж байсан байна. Гэвч дээр дурдсан хүчин зүйл Түшээт хан оросыг түшихээр очих нүүргүй болгосон байв. Мөн Галдан бошигт Халх руу цэргээ дагуулж орохдоо Орос улсаас тусламж авсан мэт худал цуурхал дэгдээсэн учир Түшээт хөн Чахуундорж, өндөр гэгээн нарыг Оросоос холдуулж Манж Чин улсад дагаар ороход хүргэсэн юм.

«Галдан ба хаант Орос» хэмээх Ма Дачжэн гэдэг хүний өгүүлэлд Галдан бошигтын хаант Оростой тогтоосон харилцаа болон манжийн эсрэг Галданы тэмцлийн мөн чанарыг үгүйсгэхийг оролджээ.

Ма Дачжэн гэгч «Галдан бошигт хаант Орос улсын эзлэн түрэмгийлэгчидтэй сүлбэлдэж хятад улсын нэгдлийг бутаргах гэж оролдож байв» гэж бичжээ. Тэр Галданыг Баатар хунтайж, Сэнгэ нарын эсрэг сөргүүлэн тавьж, тэднийг хаант Орос улсын түрэмгийлэлтэй тэмцэж хятад улсын эрх ашгийг хамгаалж байсан гэх мэтээр бичжээ. Гэтэл Баатар хунтайжийг нас барсны дараа түүний орыг залгамжлагч Сэнгэ, Галдан нар Манж Чин улсын талаар түүний явууллага байсан тусгаар тогтнолын бодлогыг үргэлжлүүлсэн юм.

Зүүнгарыг Сэнгэ захирч байсан хугацаанд хилийн орчимд оршиж байсан овгуудын талаархи асуудал ахин гарч ирж, заримдаа нэлээд хурцдаж байсан юм.¹ Гэхдээ үүнээс үндэслэж Сэнгэ хятадыг хаант Оросын түрэмгийллээс хамгаалж байсан гэж үзэх нь ямар ч үндэслэлгүй хэрэг билээ. Зүүнгар тэр үед Манж Чин улсын нэг хэсэг байтугай хараат улс ч байгаагүй гэдэг бол мэдээжийн үнэн юм. Сэнгэ Манж Чин улсын улам өргөжиж байсан түрэмгийллийг харгалзан түүнтэй ямар нэгэн харилцаа тогтоохоос зайлсхийж байжээ. Галданы хувьд гэвэл Чин улсын дайсагнасан бодлого илэрхий болж байгааг харгалзан Хаант Орос улстай Баатар хунтайжийн тогтоосон сайн хөршийн харилцааг үргэлжлүүлсэн юм. Галдан Чин улстай байлдах нь гарцаагүй гэж үзэн Зүүнгарын улсын хойд хилийн аюулгүй байдлыг хангахаас гадна Оросоос тусламж авах санаатай байжээ. Хожим 1690 онд Галдан Манж Чин улстай байлдан, хүч дутагдаж Хаант Орос улсаас тусламж гуйсан боловч Сибирьт Оросын цэргийн хүч дутмаг байсан буюу нөгөө талаас Орос улс хятадтай найрамдалт харилцаагаа хэвийн болгохыг чухалчилж, 1689 онд Манж Чин улстай, Нерчүүгийн гэрээ байгуулсан учир Оросоос тусламж авах гэсэн Галданы бодол бүтээгүй билээ.

Галдан бошигтын явуулсан тэмцэл нь Монголчуудын тусгаар тогтнолыг хамгаалахад чиглэгдэж байсан юм. Галдан Халхыг манжийн эрхшээлд оруулахгүй гэж чармайж байснаас гадна мөн Зүүнгарын улсыг манжийн түрэмгийллээс хамгаалахыг оролдож байжээ. Галдан манж Чин улсад дийлэгдсэнээр манжийн түрэмгийлэгчид Төв Азид байр сууриа бататгасан юм.

Цай Цзяи, Фань Юй мэтийн хүмүүсийн бичсэн «Цэвээнравданы гавьяаны тухай» өгүүлэлд «Цэвээнравдан Галдан бошигтын эсрэг хийж байсан Зүүнгарын ард түмний тэмцэлд онцгой үүрэг гүйцэтгэсэн» (215 р тал). «Цэвээнравдан Галдантай тэмцэхийн тулд Зүүнгарт байр сууриа бэхжүүлж Чин улстай холбоо тогтоож Чин улсын дотор гарсан үймээн самууныг дарахад идэвхтэй оролцсон» (216-р тал) гэх мэтээр бичжээ.

¹ Чимиддоржиев Ш. Б. Взаимоотношения Монголии и России в XVII вв, М., 1978. 114-р тал.

Гэтэл Цэвээнравдан Зүүнгарын улсын хаан ширээг Галдантай булаацалдан манжийн түрэмгийлэгчидтэй түүний тэмцэхэд их бэрхшээл учруулж байсан боловч манжийн түрэмгийллийг эсэргүүцэн биеэ даасан бодлогыг тууштай явуулж улсаа бэхжүүлэхийг хичээж байсан юм. Манжийн байлдан эзлэгчид Зүүнгарын хүчирхэг улс бий болж улмаар Хөх нуур, цаашилбал Төвдийг алдах аюул занал тулгарсан учир Цэвээнравдантай дайтахад хүрсэн билээ.

«Цэвээнравдан Төвд рүү дайрсан явдал манай ах дүү үндэстнүүдийн доторхи дарлагч ангийн хоорондын тэмцэл байсан» гэж тайлбарлаад түүнийг Галдан Халх руу дайрсан явдалтай адилтгаж болохгүй, яагаад гэвэл тэр нь хаант Орос улсын эзлэн түрэмгийллийн стратегид нийцэж байсан юм гэх мэтээр бичжээ. Гэтэл Цэвээнравданы тэмцэл бол ангийн юм уу эсвэл үндэстний зөрчлөөр огт тайлбарлагдахгүй нь мэдээж. Цэвээнравдан бол Галдангийн адил манжийн түрэмгийллийн эсрэг Зүүнгарын ард түмний тэмцэлд зохих хувь нэмрээ оруулсан билээ.

Ингэж маоист түүхчид «Монголыг Хятадын бүрэлдэхүүн хэсэг байсан» гэсэн сэдвийг эрдэм шинжилгээний үүднээс нотлохыг оролджээ. Хятад зохиогчид их хан үндэстний дээрэнгүй үзэлдээ захирагдсан нь тэднийг түүхийн баримтыг гуйвуулахад хүргэжээ. Дээрх өгүүлүүдийг зохиогчид гол төлөв хятадын сурвалж бичгүүдэд тулгуурлаад монгол болон бусад хэл дээр байгаа сурвалж бичиг огт ашиглаагүй байна. Нөгөө талаас зохиогчид хятад сурвалж бичгийг ашиглахдаа түүнд шүүмжлэлтэй хандаагүй байна.

«Монгол түүхэн урт удаан хугацаанд тусгаар тогтносон улс байгаагүй» гэдэг завхруулгыг нотлох гэсэн нь зохиогчдыг Хятадын хувьд ч гэсэн эзлэн түрэмгийлэгч байсан манжийн дарангуйлагчдыг цагаатгахад хүргэжээ. Нөгөө талаас их хан үндэстний дээрэнгүй үзэлд захирагдан бичигдсэн эдгээр өгүүлэлд хэдий түүхийн нэлээд урт хугацааг хамаарсан үйл явдал янз бүрийн түүхэн хүмүүсийн үйл ажиллагааг тусгасан боловч агуулга, утга санааны хувьд хоорондоо онцын ялгаагүй болжээ. Ийм учраас түүх зүйн үүднээс бичигдээгүй, тухайн үеийн маоист улс төрийн бодлогын үүднээс бичигдсэн дээрх өгүүлэл шинжлэх ухааны ямар ч үнэ цэнэгүй юм.

Н. Ариунгуа